| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -                               | -                     | -2517073075.38    | -                                       |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 1,918,734,371.38                | 125,386,552.37        | 472,952,151.63    | 2,517,073,075.38                        |
| D08 | Тайлант үеийн үр дүн                       | -                               | -                     | 2457105401.23     | (59,967,674.15)                         |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 1,918,734,371.38                | 125,386,552.37        | 412,984,477.48    | 2,457,105,401.23                        |

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |                |
|-----------------------|--|-----------------------|----------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |                       |                |
| 2                     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                | 827,894,500.00        | 620,999,757.26 |
| 21                    | УРСГАЛ ЗАРДАЛ                                    | 827,894,500.00        | 620,999,757.26 |
| 210                   | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                  | 808,931,700.00        | 602,106,068.26 |
| 2101                  | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                | 558,657,700.00        | 419,391,980.65 |
| 210101                | Үндсэн цалин                                     | 427,971,300.00        | 313,498,339.79 |
| 210102                | Нэмэгдэл   | 91,691,900.00         | 68,179,792.90  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                            | 10,391,100.00         | 10,817,999.96  |

|             |  |               |               |
|-------------|--|---------------|---------------|
| 210104      | Урамшуулал   | 28,603,400.00 | 26,895,848.00 |
| 210105      | Гэрээт ажлын хөлс  |               |               |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 69,762,400.00 | 54,061,287.61 |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 50,240,600.00 | 37,621,017.49 |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 4,911,700.00  | 4,407,676.45  |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 3,929,500.00  | 3,391,741.15  |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 971,000.00    | 769,037.12    |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 9,709,600.00  | 7,871,815.40  |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 57,400,000.00 | 56,472,410.00 |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 8,080,000.00  | 7,170,660.00  |
| 210302      | Түлш, халаалт  | 48,000,000.00 | 47,981,750.00 |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 1,320,000.00  | 1,320,000.00  |
| 210304      | Байрны түрээс  |               |               |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 23,562,800.00 | 19,854,010.00 |
| 210401      | Бичиг хэрэг  | 4,392,300.00  | 3,957,100.00  |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 4,038,200.00  | 4,029,280.00  |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 4,256,000.00  | 3,399,100.00  |
| 210404      | Ном, хэвлэл  | 1,017,700.00  | 497,500.00    |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 4,801,500.00  | 2,976,000.00  |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 5,057,100.00  | 4,995,030.00  |
| 210407      | Аж ахуйн материал худалдан авах зардал                               |               |               |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 44,190,900.00 | 15,243,100.00 |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 602,200.00    | 468,000.00    |
| 210502      | Хоол, хүнс   | 35,884,000.00 | 7,211,700.00  |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 7,704,700.00  | 7,563,400.00  |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 12,213,800.00 | 9,350,700.00  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 2,066,000.00  | 750,000.00    |
| 210602      | Тавилга  |               |               |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 3,010,700.00  | 1,463,600.00  |
| 210604      | Урсгал засвар  | 7,137,100.00  | 7,137,100.00  |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 3,472,000.00  | 1,395,400.00  |
| 210701      | Гадаад албан томилолт  |               |               |
| 210702      | Дотоод албан томилолт  | 3,472,000.00  | 1,395,400.00  |
| 210703      | Зочин төлөөлөгч хүлээн авах  |               |               |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 5,979,700.00  | 2,881,440.00  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж |               |               |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 2,000,000.00  | 432,000.00    |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 600,000.00    | 290,700.00    |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 1,000,000.00  | 295,740.00    |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 198,000.00    | 143,000.00    |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 1,866,700.00  | 1,720,000.00  |
| 210807      | Газрын төлбөр  | 315,000.00    | -             |

|              |   |                |                |
|--------------|---|----------------|----------------|
| <b>2109</b>  | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | 33,692,400.00  | 23,455,740.00  |
| 210901       | Бараа үйлчилгээний бусад зардал   | 11,200,000.00  | 4,607,000.00   |
| 210902       | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 22,492,400.00  | 18,848,740.00  |
| <b>213</b>   | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | 18,962,800.00  | 18,893,689.00  |
| <b>2132</b>  | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | 18,962,800.00  | 18,893,689.00  |
| 213208       | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 17,310,000.00  | 17,300,940.00  |
| 213209       | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 1,652,800.00   | 1,592,749.00   |
|              | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | 827,894,500.00 | 620,999,757.26 |
| <b>1310</b>  | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>  | 732,123,000.00 | 522,778,881.99 |
| 131001       | Улсын төсвөөс санхүүжих   | 732,123,000.00 | 522,778,881.99 |
| <b>1320</b>  | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>   | 95,771,500.00  | 94,843,800.27  |
| 132001       | Орон нутгийн төсвөөс  | 95,771,500.00  | 94,843,800.27  |
| <b>1E+05</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>  | -              | 3,377,075.00   |
| 1E+06        | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   |                | 3,377,075.00   |
| <b>4</b>     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                               |                | -              |
| <b>5</b>     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                              |                | -              |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он | Гүйцэтгэл           |   |
|-------------|--|----------|---------------------|---|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                     | -        | <b>2,600,000.00</b> |   |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | -        | <b>2,600,000.00</b> |   |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                       | -        | 2,400,000.00        |   |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                     | -        | 498,900.00          |   |
| 210604      | Урсгал засвар  | -        | 498,900.00          |   |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                       | -        | 1,901,100.00        |   |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | -        | 1,901,100.00        |   |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | -        | <b>200,000.00</b>   | - |
| 213503      | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг               |          | 200,000.00          |   |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | -        | 2,600,000.00        |   |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | -        | 2,600,000.00        |   |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | -        | 2,600,000.00        |   |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                              |          |                     |   |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                             | -        | -                   |   |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                            | -        | -                   |   |

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

---

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн судалгаа шинжилгээ, инновац, мэдээллийн технологид суурилсан “Чанартай сургалт-тогтвортой хөдөлмөр эрхлэлт” гэсэн зорилгыг хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлжээ.

- ❖ ХӨГЖИЛ-ийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- ❖ МБС-ын салбарын ажилтан, албан хаагч, суралцагчдын эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг дэмжих, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг үе шаттай бүрдүүлнэ.
- ❖ Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, нийгмийн түншлэл, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- ❖ Мэргэжлийн боловсрол, сургалтын цахим сургалтын платформ, бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, сургуулийн санхүүжилт, өөрийн орлогын бүрдүүлэлт, ашиглалтын оновчтой хэлбэрийг тогтоож мөрдүүлнэ.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг НОГООН ХӨГЖИЛ-ийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр :

- ❖ Хөдөлмөрийн зах зээл болон мэргэжлийн боловсрол сургалтын бодлого, зохицуулалтыг үнэлж дүгнэлт гаргана.
- ❖ Үндэсний мэргэшлийн хүрээтэй уялдуулан мэргэжлийн чиглэл бүрээр сургалтын агуулгын залгамж чанар уялдааг хангасан, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, ажил мэргэжлийн лавлах, мэргэжлийн боловсрол, сургалтын ерөнхий шаардлага стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж сургалтад нэвтрүүлнэ.
- ❖ Дэлхийн ур чадварын тэмцээний үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн сургалтын чанар, үр дүнг дээшлүүлнэ.
- ❖ Сургалт, үйлдвэрлэлийн зардал, материалын нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах хэрэглээний дадлыг төлөвшүүлнэ.
- ❖ Сургалтын чанарын үнэлгээ, төгсөгчдийн хөндлөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг авна.
- ❖ Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний нөөц, хүртээмжийг нэмэгдүүлж цахим санг бий болгон ашиглалтыг сайжруулна.
- ❖ Цахим сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж цахим үнэлгээ хийх нөхцөл боломжийг бүрдүүлэн, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран иргэд, суралцагчдыг нээлттэй, уян хатнаар сургалтад хамруулна.
- ❖ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрт шаардлагатай мэргэжилтэй ажиллах хүчний эрэлтийг тооцох, бэлтгэн нийлүүлэх

тогтолцоог бүхэлд нь хамруулсан “Мэргэжлийн боловсрол сургалт -ажлын байр - тогтвортой хөдөлмөр эрхлэлт -ийн зураглал,тооцооллыг гаргана.

- ❖ Ажил олгогч,сургалтын байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагааг дэмжсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Булган аймаг дахь ХАА-н мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2010 онд үүсгэн байгуулагдаж бүрэн дунд боловсрол олгох ХАА-н салбарт төрөлжсөн мэргэжлийн боловсрол олгох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, нийгмийн түншлэлд тулгуурласан сургалтын үйл ажиллагаагаа явуулах үндсэн чиг үүрэгтэй.

Тус мэргэжил сургалтын төв нь 2022 онд дараах чиглэлээр сургалт явуулсан байна.

- ❖ Ойжуулагч- 2.5 жил, 1 жил
- ❖ Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан – 2.5 жил, 1 жил
- ❖ Жимс, жимсгэнийн аж ахуйн фермер- 2.5 жил, 1 жил
- ❖ Хүнсний ногооны фермер – 2.5 жил, 1 жил
- ❖ Хүлэмжийн аж ахуйн фермер – 2.5 жил, 1 жил
- ❖ ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин – 2.5 жил, 1 жил
- ❖ Тракторын механик - 1 жил
- ❖ Малын асаргаа – 1 жил
- ❖ Фермерийн аж ахуй эрхлэгч – 1 жил
- ❖ Зөгийчин,зөгийн аж ахуй эрхлэгч- 1 жил
- ❖ Малчин-1 жил зэрэг мэргэжлийн ангиуд элсэлт авч сургалтын үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой МУЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 23 дугаар “тогтоолд өөрчлөлт оруулах, тогтоолын хавсралт шинэчлэн батлах” тухай тогтоолоор Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 265 дугаар “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” тогтоолын "2.4-д “Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар (Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтэстэй)” гэсэн заалтын дагуу 2022 онд БШУЯ-нд шилжин үйл ажиллагаа явуулжээ.

Байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг 2022 оны ажлын төлөвлөгөөнд 12 хяналт шалгалт хийхээр тусгаж, хэрэгжүүлж биелэлтийг тооцсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,967.67 сая төгрөгөөр буюу 2.38 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт<br>Б                                | /мянган төгрөгөөр/  |                      |                    |
|--|---------------------|----------------------|--------------------|
|  | Эхний үлдэгдэл<br>1 | Эцсийн үлдэгдэл<br>2 | Өөрчлөлт<br>3=2-1  |
| Мөнгөн хөрөнгө                               | 00.0                | 00.0                 | 00.0               |
| Авлага                                       | 00.0                | 00.0                 | 00.0               |
| Бараа материал                               | 166,194.80          | 166,966.90           | 772.10             |
| Үндсэн хөрөнгө                               | 2,350,878.27        | 2,290,138.49         | (60,739.78)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>2,517,073.07</b> | <b>2,457,105.40</b>  | <b>(59,967.67)</b> |
| Өр төлбөр                                    | 00.0                | 00.0                 | 00.0               |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 2,517,073.07        | 2,457,105.40         | (59,967.67)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>2,517,073.07</b> | <b>2,457,105.40</b>  | <b>(59,967.67)</b> |

Бараа материалын дансны үлдэгдэл 166,966.90 мянган төгрөг болж 772.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан материалтай холбоотой байна. Тайлант онд үнэ төлбөргүй шилжиж ирсэн бараа материал байхгүй байна. Тайлант онд 95521.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, байгууллагын даргын тушаалаар ашиглалтгүй, эвдэрсэн 12,345.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгажээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,290,138.4 мянган төгрөг болж өмнөх оноос 60,739.7 мянган төгрөгөөр буурсан нь үлдэх өртөггүй дахин ашиглах боломжгүй хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор акталж данснаас хассантай холбоотой байна. Үндсэн хөрөнгө хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 6319.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Авлага, өр төлбөрийн данс нь эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,221,387.9 мянга, үйл ажиллагааны орлогоос 3,000.0 мянган төгрөгөөр, нийт

зарлагыг 1,221,387.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,221,387.90 зардлыг сая, 381,203.40 зардлыг сая төгрөгөөр бууруулж, 840,184.50 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотой Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих төсвийг 12,290.00 мянган төгрөгөөр бууруулж 732,123.00 мянган төгрөг болгон баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 732,123.0, орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилтэд 95,711.5 мянган төгрөгийг авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 732,123.0, орон нутгийн төсвөөс 95,711.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 3,377.07 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 620,999.8 мянган төгрөг буюу 75.0 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 139,265.7, НДШ-ийг 15701.1, хангамжийн зардал 3708.8, норматив зардал 28947.8, томилолтын зардлыг 2076.6, бусдаар гүйцэтгүүлэх зардлыг 3098.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж үндсэн үйл ажиллагааны зардлаас 209,544.11 сая, тогтмол зардлыг 927.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ              | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Биелэлт |
|-----|------------------------------------|------------|-----------|----------|---------|
| 1   | 80101-үндсэн үйл ажиллагаа         | 677276.2   | 500050.5  | 177225.6 | 73.83   |
| 2   | 81806-дотуур байрны үйл ажиллагаа  | 35884.0    | 7211.7    | 28672.3  | 20.10   |
| 3   | 80802-ажил олгогчоос олгох тэтгэмж | 18962.8    | 18893.6   | 69.1     | 99.64   |
| 4   | 80111- тогтмол зардал              | 57400.0    | 56472.4   | 927.6    | 98.38   |
| 5   | 80112- нийтлэг үйлчилгээ           | 36371.4    | 36371.3   | 1.09     | 99.99   |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд 2600.0 мянган төгрөгийг орлого бүрдүүлжээ. Үүнээс урсгал засварт 498.9, хичээл үйлдвэрлэлийн зардалд 1901.1 мянган төгрөгийг зарцуулж 200.0 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалтын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 827,894.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16,557.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж албан хэрэгцээний авто машиныг 4 сараас эхлэн ашиглалтыг багасгаж, тээвэр шатахууны зардлыг зөвхөн дадлагын трактор, техник хэрэгсэлд ашигласан, цалингийн зардлыг 139,265.7, хангамжийн зардал 3708.8, норматив зардал 28947.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш 60296.7 мянган төгрөгийн 8 гүйлгээ гарч мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3927.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч биелэлтийг байгууллагын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 45 тоот албан бичгээр хариу ирүүлж, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |        |     | Биелэлт |      |
|-----------------|------------------------|--------|-----|---------|------|
|                 | Тоо                    | Дүн    | Тоо | Дүн     | Хувь |
| Акт             |                        |        |     |         |      |
| Албан шаардлага |                        |        |     |         |      |
| Зөвлөмж         | 2                      | 3927.0 | 2   | 3927.0  |      |
| Нийт дүн        |                        |        |     |         |      |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, дадлагын ажлын тоног төхөөрөмж, материал зэрэгт биет тооллогыг хийхийг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

##### 5.3 Зөвлөмж

Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул менежментийн захидал болон зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.